МАГАДЛАЛ - 2

1. Нэгээс мянга хүртэлх тоонуудаас таамгаар нэгийг авахад тэр нь 7-д хуваагдах тоо байх магадалалыг ол. /2007он/

(A) $0,068$ (B) $0,069$ (C) $0,007$ (D) $0,072$ (E) $0,142$

2. "Төгсөлт" гэдэг үгнээс 2 үсэг дарахад хоёулаа гийгүүлэгч байх магадлалыг олоорой. /2016он/

(A) $\frac{1}{3}$ (B) $\frac{5}{7}$ (C) $\frac{10}{21}$ (D) $\frac{7}{9}$ (E) $\frac{4}{5}$

3. Цүнхэнд 4 хөх, 4 улаан, 4 шар харандаа байв. Цүнхнээс таамгаар 2 харандаа авахад ижил өнгийн харандаа таарах магадлалыг ол. /2010он/

(A) $\frac{3}{11}$ (B) $\frac{1}{6}$ (C) $\frac{3}{7}$ (D) $\frac{1}{11}$ (E) $\frac{2}{3}$

4. Хэлбэр хэмжээгээрээ ижил 13 улаан , 13 цэнхэр бөмбөгийг тэнцүү тоотой 2 хэсэгт санамсаргүйгээр хуваахад аль нэг хэсэгт нь 11 улаан , 2 цэнхэр бөмбөг байх магадлалыг ол. /2008он/

(A) $\frac{A_{13}^{2}A_{13}^{11}}{A_{26}^{13}}$ (B) $\frac{1}{7}$ (C) $\frac{C_{13}^{2}C_{13}^{11}}{C_{26}^{13}}$ (D) $\frac{2C_{13}^{1}C_{13}^{11}}{C_{26}^{13}}$ (E) $\frac{1}{13}$

5. Хайрцагт байгаа 1-р төрлийн 5 ширхэг, 2-р төрлийн 7 ширхэг алимнаас таамгаар 2 ширхэгийг сонгон авахад тэдгээр нь өөр өөр төрлийн алим байх үзэгдлийн магадлалыг ол.

(A) $\frac{2}{33}$ (B) $\frac{35}{66}$ (C) $\frac{1}{33}$ (D) $\frac{1}{66}$ (E) $\frac{7}{5}$

6. Бүх талс нь будагтай кубыг 1000 ширхэг тэнцүү кубэд хуваав. Эдгээр кубүүдээс таамгаар нэгийг сонгоход ядаж 1 талс нь будагтай куб таарах магадлалыг ол. /2012он/

(A) $\frac{12}{125}$ (B) $\frac{61}{125}$ (C) $\frac{48}{125}$ (D) $\frac{13}{125}$ (E) $\frac{64}{125}$

7. Гар утасны дугаарын эхний 4 оронгийн цифрүүдийн нийлбэр сүүлчийн 4 оронгийн цифрүүдийн нийлбэртэй тэнцүү байвал "аз"-тай дугаар гэе. 9499**59 хэлбэрийн дугаартай хэрэглэгч азтай дугаар барих магадлалыг ол. /2014он/

(A) 0.02 (B) 0.05 (C) 0.04 (D) 0.2 (E) 0.01

8. Нэгж радиустай дугуй дотроос таамгаар нэг цэг авахад дугуйн төвөөс $\frac{1}{4}$ – ээс бага зайд байх магадлалыг ол. /2015он/

(A) $\frac{1}{16}$ (B) $\frac{1}{2}$ (C) $\frac{15}{16}$ (D) $\frac{3}{4}$ (E) $\frac{1}{4}$

9. Хайрцагт 6 улаан, 3 хөх бөмбөг байв. Хайрцагнаас таамгаар 2 бөмбөг буцааж хийхгүйгээр дараалан нэг нэгээр нь авахад эхэлж авсан бөмбөг нь улаан, дараа нь авсан бөмбөг хөх байх магадлалыг ол. /2015он/

(A) $\frac{1}{15}$ (B) $\frac{2}{9}$ (C) $\frac{1}{4}$ (D) $\frac{15}{56}$ (E) $\frac{1}{2}$

10. Түрийвчинд 20000-тын дэвсгэрт 8ш, 10000тын дэвсгэрт 9ш, 5000-тын дэвсгэрт 7 ширхэг байв. Таамгаар нэг дэвсгэрт сугалахад 10000-тын дэвсгэрт байх магадлалыг ол. /2016он/

(A) $\frac{3}{8}$ (B) $\frac{4}{5}$ (C) $\frac{9}{7\cdot 8\cdot 9}$ (D) $\frac{1}{2}$ (E) $\frac{7}{24}$

LIVEWORKSHEETS